



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1/269

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулсан аймгийн нэгдсэн зөвлөгөөний үйл ажиллагааны зардалд зориулан 18,004,830 төгрөгийг хавсралтаар батлан зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 18,004,830 төгрөг (арван найман сая дөрвөн мянга найман зуун гуч)-ийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.1-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1336

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 16-ны өдрийн
А/269 дугаар захирамжийн
хэвсрэлт



**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НЭГДСЭН
ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

| № | Үйл ажиллагаа | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ /төг/ | Нийт дүн /мян.төг/ | Тайлбар |
|------------|--|-------------|------------|----------------|--------------------|---|
| 1. | Сургалтад оролцох төлөөлөгчдийн үдийн хоолны зардал | ширхэг | 276 | 10000 | 2,760,000 | Хоолны зардал |
| 2. | Ерөнхийлөгчийн тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас ирсэн зочдын буудал, хоолны зардал | багц | 1 | 4860200 | 4,860,200 | Улаанбаатараас ирсэн 7 төлөөлөгчийн буудал, хоолны зардал |
| 3. | Жаазтай АЗ-ийн төлөвлөлтийн зураг | ширхэг | 17 | 35000 | 595,000 | Сумдын Засаг дарга нарт 1га газарт хийгдэх мод үржүүлгийн газрын зураг |
| 4. | Фото цаас | боодол | 8 | 11750 | 94,000 | Танилцуулга, гарын авлага хэвлэх |
| 5. | Гарын бэлэг | ширхэг | 1 | 1600000 | 1,600,000 | Бүрэн тоногтой эмээл |
| 6. | Зочдын өрөөнд ундаа ус, жимс | багц | 1 | 210300 | 210,300 | Улаанбаатраас ирсэн зочид төлөөлөгчдийн өрөөнд |
| 7. | Бичиг хэргийн зардал | ширхэг | 150 | 3500 | 525,000 | Зөвлөгөөнд оролцогчид, төлөөлөгчидөд бал, дэвтэр |
| 8. | Даавуун тор | ширхэг | 150 | 6000 | 900,000 | Зөвлөгөөнд зориулсан тор |
| 9. | Зөвлөгөөний үдийн цай | ширхэг | 120 | 4500 | 540,000 | Үдийн цайны завсарлага |
| 10. | Мандатны уут, оосор | ширхэг | 150 | 5000 | 750,000 | Мандатын уут, оосор |
| 11. | Модлог мөчир авах | ширхэг | 20000 | 155 | 3,100,000 | Сэлэнгэ аймгаас авсан 2-3 настай модны суулгац |
| 12. | Ногооны үр /170кг/ | багц | 1 | 2,070,330 | 2,070,330 | Лууван 100кг, манжин 30кг, хүрэн манжин 30кг, тарвас 4кг, буйцай 6кг үрний 20 хувийн төлбөр |
| Дүн | | | | | 18,004,830 | - |

-oOo-